

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/32.

Арвайхээр

“Эрүүл мэндийн албаны гамшгийн бэлэн байдлын  
нөөцийг хүлээлгэн өгөх тухай”

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.3, 33 дугаар зүйлийн 33.1.7, Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Ажиллах журам, бүрэлдэхүүн, ажил үүргийн хуваарь батлах тухай” А/43 дугаар тушаалын 3.2 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн албаны гамшгаас хамгаалах бэлэн байдлын эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодисын нөөцийг Яаралтай, гамшгийн үеийн тусламж хариуцсан мэргэжилтэн (М.Ганцэцэг)-т хүлээлгэн өгөхийг Захиргаа санхүү нийтлэг үйлчилгээний албаны дарга (Б.Валя)-д даалгасугай.

2. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын өрөөний нөөцийг 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр хүлээлцэхийг Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга (Ю.Ичинноров), нягтлан бодогч (Ц.Батжаргал), хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан ажилтан (П.Цэнгэлбаяр) нарт үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн албаны гамшгаас хамгаалах нөөцийн санхүүгийн тооцоог хийж, цахим мэдээллийн сан бүрдүүлэхийг нягтлан бодогч (Ц.Батжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ